



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/352

Ховд

Хэсэгчлэн хөл хорио тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 07 дугаар шийдвэрийг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт тарваган тахал өвчний тохиолдол гарсантай холбогдуулан урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, хамгаалах зорилгоор Ховд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасаг, Цэцэг сумын Хүн эмнэлэгт хорио цээрийн дэглэмийг тодорхойгүй хугацаагаар үргэлжлүүлэн тогтоосугай.

2. Жаргалант, Цэцэг сумдын нутаг дэвсгэрээс гарах, орох нийтийн болон хувийн тээврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 13.00 цагаас эхлэн нээсүгэй.

3. Хорио цээрийн дэглэм тогтоосон байгууллагуудад хяналт тавьж, дэглэмийг мөрдөн ажиллахыг Баруун бүсийн төв- Ховд аймгийн Онцгой байдлын газар /Б.Алтанбадралт/, аймгийн Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, Зооноз өвчин судлалын төв /Б.Баяржаргал/ нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/340, 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/345 дугаар захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02-015/7  
D/Zax-A/352-Bo